



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ  
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ 23 ТООТ ГЭРЭЭНИЙ  
2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭСЭН АКТ

2021 оны 12 дугаар сарын 3-ны өдөр

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

Гэрээний нэр	Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэх
Гэрээний дугаар	23
Захиалагч байгууллага	Сангийн яам
Захиалагч байгууллагыг төлөөлөх эрх бүхий нэгж	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар
Гүйцэтгэгч байгууллага	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг
Гэрээгээр ажил эхлүүлсэн хугацаа	2021 оны 1-р сарын 1
Гэрээт ажлыг дүгнэсэн хугацаа	2021 оны 12-р сарын 3

2. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

Гэрээний үүргийн нөхцөл	Хэрэгжилт	Биелэлт /хувиар/
2.1.1 ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтыг “Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам”-д заасны дагуу зохион байгуулах, шалгалтын үйл явцыг бүрэн цахимжуулах;	<p>1. <u>ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах бүрэлдэхүүнийг томилоход санал хүргүүлэх.</u> 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 02/35 тоот дугаартай албан бичгээр ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын бүрэлдэхүүн томилуулах албан бичиг хүргүүлсэн. Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн №64 тоот тушаалаар Татварын мэргэшсэн зөвлөхийн эрх олгох, сунгах шалгалт зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг томилсон.</p> <p>2. <u>Татварын мэргэшсэн зөвлөх /ТМЗ/ - ийн эрх олгох, сунгах шалгалтыг зохион байгуулах.</u> ТМЗ-ийн эрхээ 2021 оны эхний хагас жилд сунгуулах гишүүдийн шалгалтыг 6 дугаар сарын 14, 23-ны өдрүүдэд зохион байгууллаа. 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт</p>	100%



	<p>113 гишүүд ТМЗ-ийн эрхээ сунгуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Анх удаа эрхээ сунгуулж буй 31 ТМЗ,</li> <li>- Дахин эрхээ сунгуулж буй 45 ТМЗ тус тус шалгалтад хамрагдсан,</li> <li>- Шалгалтын журмын дагуу 3 болон түүнээс дээш удаа эрхээ сунгуулж буй 37 гишүүн шалгалтаас чөлөөлөгдсөн байна.</li> </ul> <p>Сүүлийн хагас жилийн ТМЗ-ийн эрх сунгах шалгалтыг 12 сарын 17, 20-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>ТМЗ-д эрх олгох шалгалтыг 6 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус шалгалтад Улаанбаатар хотоос 341-н, Орон нутгаас 88-н, нийт 429-н нягтлан бодогч хамрагдаснаас Улаанбаатар хотоос 170-н, Орон нутгаас 42-н, НИЙТ 212-н нягтлан бодогч ТМЗҮтХ болон ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалт авах журмын шаардлага ханган ТМЗ-ийн эрхийг авлаа.</p> <p>Сүүлийн хагас жилийн ТМЗ-ийн эрх олгох шалгалтыг 12 сарын 21-22-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна</p> <p><u>3. ТМЗ-д эрх олгох, сунгах шалгалтын тестийн санг хичээл бүрээр нэмэгдүүлэх.</u></p> <p>ТМЗ-ийн эрх олгох болон сунгах шалгалтын тестийн санг нэмэгдүүлэх зорилгоор нийгэмлэгийн сургалтад хичээл заадаг багш нараас сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгад нийцсэн тестийг сэдэв тус бүрээр боловсруулж авах ажлыг зохион байгууллаа.</p> <p>СТОУС-ын хэрэглээ</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сонголтот тест – 115</li> <li>✓ Бодолттой тест - 58</li> </ul> <p>Татварын онол</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тийм үгүй гэх тест -112</li> <li>✓ Сонголттой тест – 29</li> </ul> <p>Хууль эрх зүй</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тийм үгүй гэх тест – 50</li> <li>✓ Сонголттой тест – 125</li> </ul> <p>Санхүү, өртөг удирдлага</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сонголтот тест – 87</li> <li>✓ Бодолттой тест - 225</li> </ul> <p>Англи хэл</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Сонголтот тест – 30</li> <li>✓ Бодолттой тест - 40</li> </ul>	
--	---	--



	<p>Эрх сунгах</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Тийм үгүй гэх тест - 30</li> <li>✓ Сонголтот тест – 159</li> <li>✓ Бодолттой тест – 15-аар тус тус нэмэгдүүлсэн байна.</li> </ul>	
<p>2.1.2 Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ /цаашид ТМЗҮ гэх/ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг мэргэжлийн аргазүй, аргачлалаар хангах зорилго бүхий ТМЗ үйл ажиллагааны ерөнхий удирдамжийг шинэчлэн, сайжруулах;</p>	<p>4. <u>ТМЗҮ-ний үйл ажиллагааны удирдамжийг баталж, хэвлүүлэх, хуулийн этгээдэд тараах, мөрдүүлэх.</u></p> <p>2016 онд боловсруулсан Татварын зөвлөх үйлчилгээний ерөнхий стандарт"-ыг "Татварын зөвлөх үйлчилгээний үйл ажиллагааны удирдамж" болгон өөрчилж, шинэчилсэн найруулгыг Удирдах зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 007 тоот тогтоолоор батлуулсан.</p> <p>Удирдамж нь татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээг олон улсын жишиг стандартад нийцүүлэх, гишүүд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд гүйцэтгэх үүрэг, түүнд тавих шаардлагыг тогтоох, татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээд болон гишүүдийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангах, чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, хуулийн хүрээнд мэргэжлийн төвшинд ажиллахад нь туслах зорилготой.</p> <p>ТМЗҮ-ний үйл ажиллагааны удирдамжийг 100 ширхэг хэвлүүлж 2021 оны 2 дугаар сард татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдүүдэд хүргүүлсэн болно.</p> <p>5. <u>Үйл ажиллагааны удирдамжийг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих, ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх.</u></p> <p>Удирдамжийг хэрэглээнд нэвтрүүлснээс хойш ТМЗҮ-ний үйл ажиллагааны удирдамжийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал хүсэлтийг тогтмол авч байгаа бөгөөд одоогоор өөрчлөлт оруулах тухай санал ирүүлээгүй, үйл ажиллагаандаа нийцүүлэн хэрэглэж байгаа тухай мэдээлэл ирүүлсэн болно.</p>	<p>100%</p>
<p>2.1.3 ТМЗҮ эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг</p>	<p>6. <u>ТМЗҮ эрхлэх хуулийн этгээдийн цахим мэдээллийн санг шинэчлэн, хөгжүүлэх.</u></p> <p>ТМЗ болон ТМЗҮ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн цахим мэдээллийн санг хөгжүүлэх ажил хийгдлээ. Ингэснээр тусгай</p>	<p>100%</p>





<p>хамтран хэрэгжүүлэх, бүртгэлийн цахим мэдээллийн санг хөгжүүлэх;</p>	<p>зөвшөөрлийн цахим систем буюу <a href="http://www.license.mof.gov.mn">www.license.mof.gov.mn</a> сайтаас ТМЗХЭ болон ТМЗ гишүүдийн мэдээллийг 4 хувилбараар харах, хэрэглэх боломжтой болсон. Үүнд:</p> <p>1. <u>Зөвшөөрөлтэй байгууллагууд</u> цэсэнд</p> <p>1.1 Татварын мэргэшсэн зөвлөхийн тусгай зөвшөөрөл /Байгууллагаар/ гэж орсон. Энэ цэснээс ТМЗҮ-ийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийн мэдээллийг жагсаалтаар харах болон тодорхойлолтыг хэвлэх боломжтой. Цахим системд ТМЗҮ-ийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүд нь ТМЗҮ-ний тухай хуульд заасан Татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдэд тавигдах шаардлага болон Зөвлөх үйлчилгээ эрхлэх этгээдэд тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийг цахимаар оруулна. Ингэснээр тусгай зөвшөөрлийн цахим систем дээр ТМЗ үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагаа хангаж буй эсэх байнгын шалгуур ажиллаж, Сангийн яамнаас үйл ажиллагаанд нь цахим хяналт тавих боломж бүрдсэн.</p> <p>1.2 Татварын мэргэшсэн зөвлөхийн сертификат /Иргэнээр/ гэсэн цэснээс ТМЗ гишүүдийн мэдээллийг жагсаалтаар харах боломжтой болсон.</p> <p>2. <a href="http://www.license.mof.gov.mn">www.license.mof.gov.mn</a> сайтруу хэрэглэгч <u>өөрийн болон аж ахуйн нэгжийн эрхээр нэвтэрч</u></p> <p>2.1 ТМЗ-ийн гэрчилгээгээ харах болон хэвлэх боломжтойгоос гадна ТМЗ үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах хүсэлтийг гаргах, шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой болсон.</p> <p>2.2 ТМЗ гишүүдийн мэдээллийг жагсаалтаар харах боломжтой болсон.</p>	
---	---	--



<p>2.1.4 Сангийн яамны НБББГ-аас 2020 онд гаргасан “Боловсролын олон улсын стандартуудыг хэрэгжүүлэх талаар мэргэжлийн байгууллагуудад өгөх зөвлөмж”-ийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.</p>	<p><u>7. ТМЗ-ийн эрх олгох, сунгах сургалтын хөтөлбөрийг шинэчлэх.</u></p> <p>ТМЗН-ийн бүх шатны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр 03/80 албан тоотоор СЯ-нд хүргүүллээ. “ТМЗ-ийн эрх олгох болон сунгах сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах” ажлын хүрээнд ТМЗ нийгэмлэгийн гүйцэтгэх захирлын 2021 оны 4 дүгээр сарын 9-ний 02/013 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаа.</p> <p>Ажлын хэсэг нь ТЭХ-ийн 75.5 ба ТМЗҮТХ-ийн 15 дугаар зүйлийн 1.3; 16 дугаар зүйлийн 16.1.5; 18 дугаар зүйлийн 2.4 дахь заалт, “Татварын мэргэшсэн зөвлөхөд эрх олгох, сунгах шалгалт авах журам” зэрэг эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах болон татварын хүрээний цогц мэдлэг, дадал эзэмшсэн мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээнд үндэслэсэн боловсрууллаа.</p> <p>Хөтөлбөрийг боловсруулахдаа холбогдох баримт бичгүүд болон дотоод, гадаадын тусгай зөвшөөрөл, гэрчилгээ өгдөг ижил төстэй байгууллагуудын туршлага, цаашдын чиг хандлагын судалгаанууд хийж тэдгээрийн гарсан үр дүнг ашигласан болно.</p> <p><u>8. ТМЗҮ-ний олон улс дахь тогтолцоо, эрхзүйн орчны харьцуулсан судалгаа хийж, Сангийн яаманд танилцуулах.</u></p> <p>ТМЗҮ-ний олон улс дахь тогтолцоо, эрхзүйн орчныг харьцуулсан суурь судалгааг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 03/83 тоот албан бичгээр Сангийн яамны НБББГ-т хүргүүлсэн болно. Энэхүү судалгааг ТМЗН нь “Интоор Эккаунт Аудит” ХХК-тай хамтран дараах хүрээнд хийж гүйцэтгэсэн болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>- МУ дахь ТМЗҮ-нд оролцогч талууд, тэдгээрийн ажиллах хүрээ</li> <li>- ОУБ-уудын гишүүн орнуудын Татварын удирдлагууд болон ТМЗҮ-нд оролцогч талууд</li> <li>- Олон улсны хэмжээнд хийдэг судлаач, эрдэмтдийн судалгааны хамарсан хүрээ</li> </ul>	<p>76%</p>
---	---	------------

	<p>Дэлхийн нийт 232 улс орны татварын тогтолцоо, татварын удирдлагууд болон татварын зөвлөхүүдийн үйл ажиллагааг бүрэн хамарсан судалгааг богино хугацаанд хийх боломжгүй тул OECD болон бусад ОУБ-уудын бэлтгэсэн албан ёсны судалгаа, материалууд дээр үндэслэн, судалгааг хийсэн.</p> <p><u>9. Бусад улс орны санхүүгийн болон татварын жилийн талаарх харьцуулсан судалгаа хийж, Сангийн яаманд танилцуулах.</u></p> <p>Судалгааг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр 03/83 тоот албан бичгээр Сангийн яамны НБББГ-т хүргүүлсэн болно. Энэхүү судалгааны ажлаар загвар болгосон улс орнуудын санхүүгийн болон татварын жилийн ялгаатай байдал, санхүүгийн болон татварын тайлангаа тушаах хугацааг ямар хугацаанд хэрхэн хамаарч буйг тодорхойлохыг зорьсон болно.</p> <p>Дэлхийн нийт 150 улс орны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан тушаах хугацаа, Ази номхон далайн бүсийн орнууд болон Европын зарим улс орнуудын санхүүгийн тайлан тушаах хугацааны талаар PWC болон бусад ОУБ-уудын бэлтгэсэн албан ёсны судалгаа, материалууд дээр үндэслэн, улс орнуудын татварын тайлан тушаах хугацаа өөр өөр байгаа шалтгаан түүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийн талаар судалгаагаа хийлээ.</p>	
--	---	--

#### Тайлагнах үүрэг хариуцлага

ТМЗН-ийн 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 02/97 тоот албан бичгээр 2020 оны үйл ажиллагааны тайланг, 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02/27 тоот албан бичгээр жилийн эцсийн санхүүгийн тайланг захиалагч талд хүргүүлж ажилласан байна.



Үндсэн орон тооны ажилтан

Албан тушаал	Нэр	Тавигдах шаардлага	Чухал шаардлага, ур чадварын хангасан байдал
Ерөнхийлөгч	Г.Алтанзаяа	Дээд боловсролтой, Доктор, профессор	ТМЗН-ийн үүсгэн байгуулагч, 2004 оноос хойш нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, ерөнхийлөгчөөр ажиллаж байна. Татварын бүртгэл, нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн чиглэлээр 22 ном гаргаж, 22 илтгэл, 20 өгүүлэл хэлэлцүүлж, 8 төсөл, судалгааны ажил хийсэн байна. МУ-ын ТМЗ, МНБ
Гүйцэтгэх захирал	Ц.Болормаа	Дээд боловсролтой	2005 оноос хойш ТМЗН-т сургалтын менежер, ажлын албаны дарга, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
Тамгын газрын дарга	Г.Хишигзул	Дээд боловсролтой, магистр зэрэгтэй	2010 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогч, нягтлан бодох бүртгэлийн багш, тамгын газрын даргаар ажиллаж байна. МУ-ын ТМЗ, МНБ
Сургалтын менежер	О.Батсүх	Дээд боловсролтой	2018 оны 12 сараас хойш сургалтын менежерээр ажиллаж байна.
Ерөнхий нягтлан бодогч	П.Дашдаваа	Дээд боловсролтой, магистр зэрэгтэй	2019 оноос хойш ТМЗН-т нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна. Нягтлан бодогч, хуульч мэргэжилтэй. МУ-ын ТМЗ.
Мэдээлэл технологийн инженер	Ү.Ганболд	Дээд боловсролтой	2016 оноос хойш ТМЗН-т мэдээлэл технологийн инженерээр ажиллаж байна.
Гишүүд, орон нутгийн салбар хариуцсан менежер	Ц.Хажидмаа	Дээд боловсролтой	2006 оноос хойш ТМЗН-т Гишүүд, орон нутаг хариуцсан менежерээр ажиллаж байна.
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах менежер	Г.Цэрэндулам	Дээд боловсролтой, Сэтгүүлч мэргэжилтэй	2018 оноос хойш ТМЗН-т хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах менежерээр байна.





Нярав/ Бичиг хэргийн ажилтан	Ш.Даваажаргал	Дээд боловсролтой,	2017 оноос хойш ТМЗН-т туслах ажилтан, нярав, бичиг хэргийн ажилтнаар ажиллаж байна.
Судалгааны төвийн менежер	Б.Энхтуул	Дээд боловсролтой	2020 оны 10-р сараас хойш ТМЗН-т Судалгааны төвийн менежерээр ажиллаж байна

**Орон тооны бус бүрэлдэхүүн**

<i>Албан тушаал</i>	<i>Тавигдах шаардлага хангасан байдал</i>
Удирдах зөвлөл	ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит V их хурлаар /2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн/ удирдах ажлын туршлага, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий ТМЗ гишүүд удирдах зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 13 гишүүн сонгогдсон болно.
Хяналтын зөвлөл	ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит V их хурлаар удирдан зохион байгуулах туршлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвар бүхий татварын мэргэшсэн зөвлөх гишүүд хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэн санал хураах зарчмаар 5 гишүүн сонгогдсон болно.
Менежментийн хороод	ТМЗН-ийн бүх гишүүдийн ээлжит V их хурлаар баталсан шинэчилсэн дүрмээр ТМЗН нь <ul style="list-style-type: none"> <li>✓ Мэргэжлийн үйлчилгээ, бодлогын менежментийн хороо</li> <li>✓ Сургалтын менежментийн хороо</li> <li>✓ Судалгааны менежментийн хороо</li> <li>✓ Мэргэжлийн хариуцлага, ёс зүйн менежментийн хороо</li> <li>✓ Хууль эрх зүйн менежментийн хороо гэсэн таван хороотой болсон бөгөөд хороодын даргыг удирдах зөвлөлийн гишүүдээс 2 жилийн хугацаатай сонгосон.</li> </ul> Хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах хүсэлтийг бүх гишүүдээс нээлттэй авч, бүрэлдэхүүнийг томилсон болно.

**Үйлчилгээ үзүүлэгчийн техник хэрэгсэл**

<i>№</i>	<i>Техник хэрэгсэл</i>	<i>Тайлбар</i>
1	Сургалтын анги танхим	60 суралцагчийн багтаамжтай танхим, ухаалаг дэлгэц, шууд дамжуулалтын хяналтын дэлгэц, шууд дамжуулалтын камер, микрофон, компьютер зэрэг иж бүрэн хэрэгслээр тоноглогдсон.
2	Сурах бичиг гарын авлага	Сургалтын батлагдсан хөтөлбөрийг агуулсан ном сурах бичиг, гарын авлагын бэлтгэн, тухай бүр шинэчлэн





		суралцагчдад өгдөг.
3	Багшлах боловсон хүчин	Хичээл тус бүрт тухайн чиглэлээр ажилласан туршлагатай нарийн мэргэшсэн мэргэжилтэн, их дээд сургуулиудын багш, татварын мэргэшсэн зөвлөх нартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилладаг.

**Гэрээний хэрэгжилтийг шалгах явцад гарсан санал**

Сангийн яам	<ol style="list-style-type: none"><li>1. ТМЗН-ийн бүх шатны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн баталж, мөрдүүлэх</li><li>2. “ТМЗҮ-ний олон улс дахь тогтолцоо, эрхзүйн орчны харьцуулсан судалгаа” болон “Бусад улс орны санхүүгийн болон татварын жилийн талаарх харьцуулсан судалгаа”-нуудыг Татварын ерөнхий газарт болон татварын мэргэшсэн зөвлөхүүдэд хүргүүлэх</li><li>3. ТМЗ-ийн эрх олгох, сунгах шалгалтыг танхимд цахим хэлбэрээр зохион байгуулах нөхцөл боломжийг судлах</li></ol>
ТМЗН	<ol style="list-style-type: none"><li>1. Сангийн яамнаас татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүй хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдүүдэд хяналт тавьж, <a href="http://e-balance.mof.gov.mn">e-balance.mof.gov.mn</a> сайтад цахим мэдэгдэл байршуулах</li><li>2. ТМЗН-ээс зохион байгуулдаг бүх шатны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлах</li></ol>





**ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:**

Захиалагч талаас гүйцэтгэгч болох Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг нь гэрээний үүргээ дунджаар 94% биелүүлсэн гэж дүгнэв.

**Захиалагчийг төлөөлж:**


МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД:  
Б.ЖАВХЛАН



САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА:  
Ч.ЧИМИДСҮРЭН



САНГИЙН ЯАМНЫ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ  
ШИНЖЭЭЧ:  
Б.БОЛОРМАА



**Гүйцэтгэгчийг төлөөлж:**

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:  
Ц.БОЛОРМАА



ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХИЙН НИЙГЭМЛЭГИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:  
Г.ХИШИГЗУЛ

